МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

# ХҮСЭЛТ ИЛГЭЭХ СИСТЕМИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН

# ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2026 он

## ХҮСЭЛТ ИЛГЭЭХ НЭГДСЭН СИСТЕМИЙН НҮҮР ХУУДАС

## 1. Хайлтын хэсэг

Хайлтын хэсэг нь иргэн, байгууллагаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд илгээсэн өргөдөл, гомдол, хүсэлт, албан бичгийн бүртгэл болон шийдвэрлэлтийн явцыг бичгийн дугаар, гарчиг эсвэл агуулгын түлхүүр үгээр хайж, бодит цагийн мэдээлэлтэй танилцах боломжийг олгоно.

### Хайлтын боломж

Хэрэглэгч дараах мэдээллээр хайлт хийх боломжтой.Үүнд:

- Албан бичгийн дугаар болон өргөдөл, гомдлын дугаар;
- Албан бичгийн болон өргөдөл гомдлын тэргүү агуулга;

### Хайлтын үр дүн

Хайлтын үр дүнд дараах мэдээлэл харагдана.Үүнд:

- Илгээсэн огноо;
- Одоогийн төлөв;
- Шийдвэрлэлтийн үе шат;

### Хайлт хийх дараалал

1. Нүүр хуудасны **"Бичгийн дугаар, тэргүү агуулгаар хайх"** хэсэгт хайх утгаа оруулна.




2. Хайлтын дүрс (🔍) дээр дарж эсвэл **Enter** товчийг дарна.




3. Систем нь хайлтын нөхцөлд тохирох баримт бичгийн мэдээллийг жагсаалт хэлбэрээр харуулна.




4. Хэрэглэгч жагсаалтаас шаардлагатай баримтыг сонгон дэлгэрэнгүй мэдээлэл болон шийдвэрлэлтийн явцтай танилцах боломжтой.




## 2. Нэгдсэн дашбоард дээр харагдах мэдээлэл

Нэгдсэн дашбоард модуль нь Байгаль орчин уур, амьсгалын өөрчлөлтийн яаманд ирсэн өргөдөл, гомдол, хүсэлт, албан бичгийн бүртгэл, шийдвэрлэлтийн явц, статистик мэдээллийг нэгтгэн харуулж, иргэд болон байгууллагуудын илгээсэн баримт бичгийн шийдвэрлэлтийн явцыг ойлгомжтой, ил тод, хүртээмжтэй байдлаар хянах харах боломжийг бүрдүүлсэн.



## 3. Албан бичиг, өргөдөл гомдол илгээх модуль

### Модулийн зорилго

**"Албан бичиг, өргөдөл илгээх"** модуль нь хэрэглэгчийг шинээр баримт бичиг бүртгэн цахимаар илгээх үйлдлийг эхлүүлэх зориулалттай.

Уг товчийг дарснаар **албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлт** үүсгэх дэлгэц нээгдэх бөгөөд хэрэглэгч баримт бичгийн төрөл сонгох, шаардлагатай мэдээллийг бөглөх, холбогдох хавсралт файлыг оруулах, байгууллагад цахимаар илгээх үйлдлийг гүйцэтгэнэ.

### Шинэ хүсэлт үүсгэх

1. Нүүр хуудаснаас Албан бичиг, өргөдөл илгээх хэсгийг сонгоно.




2. Системийн нэвтрэх хэсэг рүү орно.




3. **Шинэ хэрэглэгч бол ДАН-гаар бүртгүүлэх** товчийг дарна.



4. Дангаар нэвтрэх хэсэг орж өөрийн бүртгэлээр орно.




5. Хүсэлт илгээх системд бүртгэл өгөх зөвшөөрлийн товч дээр дарна.




6. Нэвтэрч орсны дараа хэрэглэгч хувийн мэдээлэл хэсэг рүү орно.



7. Хэрэглэгчийн хувийн мэдээллийн хэсгийн нууц үг оруулах хэсэг дээр нууц үгийг оруулах боломжтой. (Жич: Дангаар нэвтрэхгүй үед нэвтрэх хэсгийн нууц үгийг үүсгэн. Хэрэглэгчийн нэвтрэх нэр РД-аар үүснэ.)




8. Хэрэглэгч системд амжилттай нэвтэрсний дараа үндсэн дэлгэцээс **"Албан бичиг"** эсвэл **"Өргөдөл, гомдол"** товчийг сонгон холбогдох баримт бичгийг цахимаар илгээх боломжтой.



## Албан бичиг

"Албан бичиг" товчийг сонгосноор албан бичиг бүртгэх дэлгэц нээгдэнэ.

1. Албан бичиг хуудасны **"Нэмэх"** хэсэгт дарна.




2. Хэрэглэгч албан бичгийн үндсэн мэдээллийг бөглөж, шаардлагатай хавсралт файлыг оруулан байгууллагад цахимаар илгээх боломжтой.




3. Хэрвээ байгууллага холбогдоогүй тохиолдолд **“Байгууллага холбох”** товч дээр дарна.



4. Хэрэглэгчийн профайл хэсэг рүү үсэрнэ. Хэрэглэгч байгууллагын РД оруулна.




5. Байгууллагын РД оруулсаны дараа холбох товч дарна.




6. Хэрэглэгчийн илгээсэн албан бичгүүд жагсаалтаар харагдана.



| Хүлээн авагч | Хариуцагч | Товч утга | Хариу өгөх огноо | Системд нэмсэн огноо | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| Хүлээн авагч | Хариуцагч | Товч утга | Хариу өгөх огноо | Системд нэмсэн огноо | Төлөв |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Боловсруулж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Судлагдаж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Сонгогдсон байгууллагуудаас яам, агентлаг, аймаг, сумд... | 2023/11/23 | 2023/11/23 | Шийдвэрл |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Хүлээгдэж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Судлагдаж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Сонгогдсон байгууллагуудаас яам, агентлаг, аймаг, сумд... | 2023/11/23 | 2023/11/23 | Шийдвэрл |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Хүлээгдэж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Судлагдаж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Сонгогдсон байгууллагуудаас яам, агентлаг, аймаг, сумд... | 2023/11/23 | 2023/11/23 | Шийдвэрл |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Море ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Хүлээгдэж |

7. Мөн өөрийн илгээсэн албан бичгийн дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.




8. Албан бичгийн хариу мэдээллийг харах боломжтой.



## Өргөдөл гомдол

"Өргөдөл гомдол" товчийг сонгосноор өргөдөл бүртгэх дэлгэц нээгдэнэ.

1. Өргөдөл хуудасны **"Нэмэх"** хэсэгт дарна.




2. Хэрэглэгч өргөдөл гомдлын үндсэн мэдээллийг бөглөж, шаардлагатай хавсралт файлыг оруулан байгууллагад цахимаар илгээх боломжтой. Мөн өргөдөл гомдлыг Иргэний хувиар болон Байгууллага төлөөлж илгээх боломжтой.







3. Хэрвээ байгууллага холбогдоогүй тохиолдолд **“Байгууллага холбох”** товч дээр дарна.




4. Хэрэглэгчийн профайл хэсэг рүү үсэрнэ. Хэрэглэгч байгууллагын РД оруулна.




5. Байгууллагын РД оруулсаны дараа холбох товч дарна.




6. Хэрэглэгчийн илгээсэн өргөдөл гомдлууд жагсаалтаар харагдана.

| Хүлээн авагч | Хариуцагч | Товч утга | Хариу өгөх огноо | Системд нэмсэн огноо | Төлөв |
|---|---|---|---|---|---|
| Хүлээн авагч | Хариуцагч | Товч утга | Хариу өгөх огноо | Системд нэмсэн огноо | Төлөв |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Боловсруулж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Судлагдаж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Сонгогдсон байгууллагуудаас яам, агентлаг, аймаг, сумд... | 2023/11/23 | 2023/11/23 | Шийдвэрл |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Хүлээгдэж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Судлагдаж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Сонгогдсон байгууллагуудаас яам, агентлаг, аймаг, сумд... | 2023/11/23 | 2023/11/23 | Шийдвэрл |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Хүлээгдэж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Судлагдаж |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | Сонгогдсон байгууллагуудаас яам, агентлаг, аймаг, сумд... | 2023/11/23 | 2023/11/23 | Шийдвэрл |
| Ворлд Инвести ХХК | **М.Солонго** | More ороод аймаг руу ороод хаахад (чагт) ажилладаг бол... | 2023/11/23 | 2023/11/23 | Хүлээгдэж |

7. Мөн өөрийн илгээсэн өргөдөл гомдлын дэлгэрэнгүй  мэдээллийг харах боломжтой.




8. Өргөдөл гомдлын хариу мэдээллийг харах боломжтой.

